Өр төлбөрийн дансны үлдэгдэлд эм ханган нийлүүлэх байгууллагад өгөх өглөг 11,106,353.4 мянган төгрөг, татварын өглөг 126,109.6 мянган төгрөг, байгууллагад өгөх өглөг 47,571.8 мянган төгрөгийн өглөг бүртгэлтэй байна.

Засгийн газрын хувь оролцоо дансны үлдэгдэл 82,770,500.3 мянган төгрөг болж 74,969,521.8 мянган төгрөгөөр буурсан нь үйл ажиллагааны нийт үр дүнтэй холбоотой байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2024 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг эрүүл мэндийн даатгалын сангаас 27,399,278.3 мянган төгрөг, үндсэн үйл ажиллагааны орлогоос 1,156,874.0 мянган төгрөг, дээд шатны байгууллагаас санхүүжих эх үүсвэрийг 19,242,758.0 мянган төгрөг, нийт зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрт 47,798,910.2 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас урсгал зардлыг 6,617,265.7 мянган төгрөгөөр бууруулж, нийт зардлыг 41,181,644.5 мянган төгрөгөөр, зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг ЭМДС-аас 17,829,195.7 мянган төгрөг, үйл ажиллагааны орлогоос 23,352,448.8 мянган төгрөг бүрдүүлэхээр баталжээ.

Төсвийг дахин тодотгож ЭМДС-аас санхүүжүүлэх эх үүсвэрийг 2,672,325.3 мянган төгрөгөөр нэмэгдүүлж 20,501,521.0 мянган төгрөг, үндсэн үйл ажиллагааны орлогыг 1,175,210.2 мянган төгрөг, туслах үйл ажиллагаанаас санхүүжих эх үүсвэрийг 22,292,074.0 мянган төгрөг болгон өөрчилж нийт 43,968,805.2 мянган төгрөгөөр баталсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Гүйцэтгэлээр эрүүл мэндийн даатгалын, тусламж үйлчилгээний санхүүжилтээс 20,501,521.0 мянган төгрөг, үндсэн үйл ажиллагааны орлогоос 1,175,210.2 мянган төгрөг, туслах үйл ажиллагааны орлогоос 22,292,074.0 мянган төгрөг, нийт 43,968,805.2 мянган төгрөгийн орлого бүрдүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 50,461,428.2 мянган төгрөг буюу 82.9 хувьтай байгаа нь батлагдсан төсвөөс цалин хөлс болон нэмэгдэл урамшлын зардлаас 4,305,256.0 мянган төгрөг, ажил олгогчоос төлөх нийгмийн даатгалын шимтгэлийн зардлаас 348,443.2 мянган төгрөг, байр ашиглалттай холбоотой тогтмол зардлаас 107,204.8 мянган төгрөг, норматив зардлаас 3,445,303.2 мянган төгрөг, эд хогшил урсгал засварын зардлаас 413,854.0 мянган төгрөг, томилолт зочны зардлаас 400,588.2 мянган төгрөг, бусад зардлаас 1,365,765.5 мянган төгрөгийг тус тус дутуу зарцуулсантай холбоотой байна.

2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/

Д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлтийн хувь
1	71602 Эмнэлгийн тусламж үйлчилгээ	60,850,843.1	50,461,428.2	10,389,414.8	82.9
1.1	80101 -Үндсэн үйл ажиллагааны зардал	24,235,538.2	20,305,106.5	3,930,431.7	83.7
1.2	80802- Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	60,000.0	17,230.0	42,770.0	28.7
1.3	81614-Элэг бүтэн Монгол хөтөлбөр	10,586,665.7	9,851,041.8	735,623.9	93.1
1.4	83601-Нэмэлт Олон улсын байгууллагаас олгосон санхүүжилт	7,395,666.0	4,157,835.6	3,237,830.4	56.1
1.5	83603-Нэмэлт Дээд шатны төсвөөс хуваарилсан	18,572,973.2	16,130,214.3	2,442,758.9	86.8

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд нийт 21,474,981.3 мянган төгрөгийн 18 бараа, ажил, үйлчилгээ худалдан авахаар төлөвлөж, баталсан байна. Үүнээс 20,300,629.5 мянган төгрөгийн 8 бараа, ажил, үйлчилгээг нээлттэй тендер шалгаруулалтаар, 524,351.8 мянган төгрөгийн 9 бараа, ажил, үйлчилгээг харьцуулалтын аргаар, 650,000.0 мянган төгрөгийн 1 бараа, ажил, үйлчилгээг ерөнхий гэрээгээр худалдан авахаар төлөвлөгөөнд тусгажээ.

Гүйцэтгэлээр эм эмнэлгийн хэрэгсэл 14,373,088.8 мянган төгрөг, тоног төхөөрөмж, хангамж, аж ахуйн материал 951,741.3 мянган төгрөг, нийт 15,323,830.1 мянган төгрөгийн худалдан авалт хийсэн ба үүнээс нээлттэй тендер шалгаруулалтаар 14,538,046.4 мянган төгрөгийн бараа, ажил, харьцуулалтын аргаар 429,010.0 мянган төгрөгийн бараа ажил үйлчилгээ, цахим дэлгүүрээс 362,773.7 мянган төгрөгийн эм, эмнэлгийн хэрэгсэл, тоног төхөөрөмж худалдан авсан байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д "Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана" гэж заасны дагуу Халдварт өвчин судлалын үндэсний төвийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийсэн төв түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан топиуулав.

Аудитыг Баян ташаагийн эх аудитын ахлах аудитор Б.Хандсүрэн, аудитор Д.Балжирдорж нар гүйцэтгэж, анхан шатны хяналтыг захирал Т.Хоролсүрэн, дараагийн шатны хяналтыг Санхүү, нийцлийн аудитын газрын аудитор Б.Отгонцэцэг, аудитын менежер В.Эрдэнэцогт, газрын захирал, тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг нар тус тус хэрэгжүүлсэн.

Халдварт өвчин судлалын үндэсний төв 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Үндэсний аудитын газарт 2025 оны 1 дүгээр сарын 23-ний өдрийн 1-1/91 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт орлогыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2023 оны жилийн эцсийн үр дүнгийн тайлангийн нийт орлого 69,759,001.0 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу 697,590.0 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор тайлант онд батлагдсан төсвөөс норматив зардлыг 3,445,303.2 мянган төгрөгөөр, цалин нийгмийн даатгалд төлөх шимтгэлийн зардлыг 4,653,699.2 мянган төгрөгөөр, тогтмол зардлыг 107,204.7 мянган төгрөгөөр, эд хогшил урсгал засварын зардлыг 179,873.2 мянган төгрөгөөр, томилолтын зардлыг 414,865.9 мянган төгрөгөөр, бусад зардлыг 526,959.9 мянган төгрөгөөр дутуу зарцуулсан байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны цахим системд орлогын 6,842,852.9 мянган төгрөгийн 24 мэдээллийг байршуулаагүй, цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын 19,235,492.3 мянган төгрөгийн 601 мэдээллийг байршуулаагүй, нийт 26,078,345.2 мянган төгрөгийн мэдээллийг байршуулаагүй байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3-т "тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх", 6 дугаар зүйлийн 6.4-д "Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ", 6.4.5-д "цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр" гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны хуулийг хэрэгжүүлээгүй, цахим системд мэдээллийг байршуулаагүй, өмнөх оны аудитаар өгсөн зөвлөмжийг биелүүлээгүй зөрчлийг таслан зогсоож, давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэв.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй гэж дүгнэлээ.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн бусад хууль, тогтоомжийн хүрээнд шалгасан зүйлийг холбогдох заалттай нийцсэн байна гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Завсрын аудитаар шалгагдагч байгууллагын 2024 оны 3 дугаар улирлын санхүүгийн тайланг хамруулж, авлага, өглөг, мөнгөн хөрөнгө, үндсэн хөрөнгө, цалин, орлогын данстын хувьд горим, сорил хэрэгжүүлж завсрын аудит хийгдсэн.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 4,950.0 мянган төгрөгийн 1 төлбөрийн акт, 3,265,263.7 мянган төгрөгийн 2 албан шаардлага, 3 зөвлөмж өгснөөс 3,265,263.7 мянган төгрөгийн 1 албан шаардлагыг хэрэгжүүлээгүй, биелэлт 83.3 хувьтай байна.

Хүснэгт 3. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Төлбөрийн акт	1	4,950.0	1	4,950.0	100.0
Албан шаардлага	2	3,265,263.7	1	-	50.0
Зөвлөмж	3		3	-	100.0
Нийт дүн	6	3,270,213.7	6	4,950.0	83.3

Эрүүл мэндийн яамнаас 2021-2022 онуудад үнэ төлбөргүй хуваарилсан 3,265,623.8 мянган төгрөгийн хугацаа дууссан оношлуур, урвалжийг нотлох баримтгүйгээр устгасныг хууль хяналтын байгууллагад шилжүүлэхээр өгсөн албан шаардлагыг хэрэгжүүлээгүй хууль хяналтын байгууллагаас шийдвэр ирээгүй байна.

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Худалдан авах үйл ажиллагаатай холбоотой оны эцэст тендер зарлагдсан 1,500,000.0 мянган төгрөгийн эмнэлэгийн хэрэгсэл, бараа ажил үйлчилгээний худалдан авалтын гэрээ он дамжин хэрэгжиж байгаа тул гэрээний биелэлтэд дараагийн аудитаар анхаарлаа хандуулах шаардлагатай байна.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 492,522.8 мянган төгрөгийн зөрчил илэрснээс, 14,196.3 мянган төгрөгийн зөрчилд 2 төлбөрийн акт, 12,568.2 мянган төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага хүргүүлж, 465,758.3 мянган төгрөгийн 2 зөрчилд алдааг давтан гаргахгүй байх зөвлөмж өгсөн.

Нийт илрүүлсэн алдаа, зөрчлөөс 492,522.8 мянган төгрөгийн залруулагдаагүй алдаа болон зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс 205,067.2 мянган төгрөгөөр бага байгаа тул "Өөрчлөлтгүй" дүгнэлт өгсөн.

5.1 Төлбөрийн акт

1. Тус төвийн орон тоо, албан тушаалын жагсаалтын дагуу хуулийн мэргэжилтэн ажилладаг бөгөөд дахин нэг хуулийн мэргэжилтэнтэй хөлсөөр ажиллах гэрээ байгуулж ажиллуулсан. Гэрээт хуулийн ажилтны ажлын гүйцэтгэлийн тайлан байхгүй мөн гэрээний хугацаа дууссанаас хойш 10 сарын ажлын хөлс 10,500.0 мянган төгрөгийг олгосон байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д "үнэн зөв байх", 20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах", Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 16.5.3-т "батлагдсан цалингийн сан, орон тооны хязгаарт багтаан төсвийн байгууллагын орон тоо, ажилчдын цалин хөлсийг тогтоох" гэж тус тус заасантай нийцээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Батлагдсан орон тооноос илүү хуулийн мэргэжилтэн ажиллуулсан, гэрээний хугацаа дууссанаас хойш олгосон ажлын хөлсийг нөхөн төлүүлэх төлбөрийн акт тогтоов.

2. Төлбөртэй үйлчилгээний цахим системийн кассын орлогыг Эрүүл мэндийн даатгалын сангийн И-Хепт программын орлоготой тулган шалгахад касс 3,696.3 мянган төгрөгийг дутуу тушаасан байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д "үнэн зөв байх", 13 дугаар зүйлийн 13.4-д "Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна", 20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил гүйлгээ гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах", Сангийн сайдын 2012 оны 276 дугаар тушаалаар баталсан "Төсвийн байгууллагын мөнгөн кассын ажиллагааны журам"-ын 2.6-д "Төсвийн байгууллага үндсэн болон туслах ажиллагаа (бусад орлого)-наас орох орлогыг мөнгөн касстаа бэлнээр хүлээн авч энэхүү орлогыг /түүнийг шууд захиран зарцуулах эрхгүй/ ажлын дараагийн өдөрт багтаан кассын нярав Төрийн сан дахь бүртгэлийн дансанд тушаана" гэсэн заалттай нийцээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөртэй үйлчилгээний орлогыг төсөвт дутуу төвлөрүүлсэн 3,696.3 мянган төгрөгийг буруутай этгээдээр нөхөн төлүүлэх төлбөрийн акт тогтоов.

5.2 Албан шаардлага

1. Тус төв нь 3 аж ахуйн нэгжтэй байгуулсан гэрээний дүнгээс 12,568.2 мянган төгрөгөөр илүү эм, эмнэлгийн хэрэгсэл худалдан авсан байна. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.2-т "Худалдан авах гэрээний үнийг гэрээ байгуулах эрх олгосон тухай шийдвэрт заасан үнээр тогтооно", Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 41 дүгээр зүйлийн 41.2.3-т "төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнах", 41.2.6-д "төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр худалдан авах бараа ажил үйлчилгээний гүйцэтгэлийн санхүүжилтийг бараа, ажил үйлчилгээ худалдан авах ажиллагааны гэрээ, төлбөрийн хуваарийг үндэслэн санхүүжүүлэх" гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Байгуулсан гэрээний үнийн дүнгээс хэтрүүлэн эм, эмнэлгийн хэрэгсэл худалдан авсан зөрчлийг таслан зогсоох, зөрчлийг давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэв.

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Нягтлан бодох бүртгэл, тайлагналтай холбоотой асуудал

1.1 Илрүүлэлт:

Төлбөртэй үйлчилгээний орлого 8,400.0 мянган төгрөгийг байгууллагын дансанд тушаахгүй хөрөнгө бэлтгээд орлого аваагүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5

дугаар зүйлийн 5.1.4-д "үнэн зөв байх", 13.4-д "Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна". 14 дүгээр зүйлийн 14.4.1-д "аж ахуйн бүх ажил, гүйлгээ", 14.4.2-т "Бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага" гэсэн заалттай нийцээгүй, иж бүрэн байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

1.2 Өгсөн зөвлөмж:

Төлбөртэй үйлчилгээний орлогыг цаг тухай бүр байгууллагын дансанд тушааж байх, дотоод хяналтыг сайжруулан ажиллах зөвлөмж өгөв.

2.1 Илрүүлэлт:

Тухайн үед мөрдөгдөж байсан ЗГ-ын 2018 оны 264 дүгээр тоот "Төрийн албан хаагчийн албан тушаалын цалингийн сүлжээ, доод жишгийг шинэчлэн тогтоох тухай" тогтоолыг үндэслэн цалинг шинэчлэн тогтоож тухайн үеийн цалингийн хүрсэн төвшин бууруулахгүйгээр ХӨСҮТ-ийн үйлдвэрчний эвлэлийн хорооны 2018 оны хамтын гэрээний 3.1-д "Ажил олгогч нь ажилтнуудын үндсэн цалин, нэмэгдэл, нэмэгдэл хөлс, шагнал урамшуулал, тэтгэвэр тэтгэмж, хөнгөлөлт унаа хоолны зардал болон бусад нөхөн олговрын хэмжээг холбогдох тогтоол шийдвэрийн дагуу бүтэн олгож, өмнөх хүрсэн төвшин бууруулахгүй аль болох нэмэгдүүлж ажиллана" гэсэн заалтуудыг үндэслэн 2019 оноос өмнө ажилд орсон ажилчдад сар бүр тогтмол цалингийн зөрүүний нэмэгдэл олгож ирсэн бөгөөд 2024 онд нийт 457,558.3 мянган төгрөгийг цалингийн сангаас олгосон.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д "үнэн зөв байх", 20 дугаар зүйлийн 20.2.4-д "нягтлан бодох бүртгэл хөтлөлт нь энэ хууль болон санхүүгийн бусад хууль тогтоомжид заасан шаардлагад нийцэж байгаа эсэхийг хянах", Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах" гэсэн заалттай нийцэхгүй байна.

2.2 Өгсөн зөвлөмж:

Үйлдвэрчний эвлэлийн хорооны 2018 оны хамтын гэрээг шинэчлэх, 2019 оноос өмнө ажилд орсон ажилчдад сар бүр тогтмол нэмэгдлийг олгож байгаа асуудлыг судалж шийдвэрлэх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2025 оны 9 дүгээр сарын 01-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил				Үүнээс				/мянган төгрөгөөр/
	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж				
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн			
Төлбөртэй үйлчилгээний орлого 8,400.0 мянган төгрөгийг байгууллагын дансанд тушаахгүй хөрөнгө бэлдэж орлого аваагүй байна	1	8,400.0					1	8,400.0	
3Г-ын 2018 оны 264 тоот Төрийн албан хаагчийн албан тушаалын цалингийн сүлжээ, доод жилийг шинэчлэн тогтоох тухай тогтоогыг үндэслэн цалинг шинэчлэн тогтоож тухайн үеийн цалингийн хүрсэн түвшин бууруулахгүйгээр ХӨСҮТ-ийн үйлдвэрчний эвлэлийн хорооны 2018 оны хамтын гэрээний 3.1-д "Ажил олгогч нь ажилтнуудын үндсэн цалин, нэмэгдэл, нэмэгдэл хөлс, шалгал урамшуулал, тэтгэвэр тэтгэмж, хөнгөлөлт, унаа хоолны зардал болон бусад нөхөн олговрын хэмжээг холбогдох тогтоол шийдвэрийн дагуу бүтэн олгож, өмнөх хүрсэн түвшнээс бууруулахгүй аль болох нэмэгдүүлж ажиллана" гэсэн заалтыг үндэслэн 2019 оноос өмнө ажилд орсон ажилчдад сар бүр тогтмол нэмэгдлийг олгосоор ирсэн байна. Тус байгууллагын 2024 оны худалдан авах үйл ажиллагааны сонгон шалгаруулалтын баримт материалыг шалгахад 10 өх ажлын нэгжээс нийтлүүлэлтийн гэрээний дүнг зөрчин 12,568.2 мянган төгрөгийн эм зинзэлийн хэрэгсэл илүү худалдан авсан байна	1	457,358.3					1	457,358.3	
Байгууллагын бугац орон тоонд хуулийн 1 ажилтантай байхад баталсан бөгөөд дахин 1 хуулийн ажилтан хөлсөөр ажиллах гэрээгээр ажиллуулж гэрээний хугацаа дууссанаас хойш 10,500.0 мянган төгрөгийн цалин хөлс олгосон байна	1	10,500.0	1	10,500.0			1	12,568.2	
Төлбөртэй үйлчилгээний цахим системийн хэсгийн орлогыг Эрүүл мэндийн даатгалын сангийн И-Хөлд программын орлоготой тулган шалгахад хэсэг 3,696.3 мянган төгрөгийг дутуу тушавсан байна	1	3,696.3	1	3,696.3					
Дүн	5	492,522.8	2	14,196.3	1	12,568.2	2	465,758.3	

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил				Үүнээс				/мянган төгрөгөөр/
	Тоо		Дүн		Албан шаардлага		Зөвлөмж		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтлэлтэй холбоотой зөрчил:

Шилэн дансны цахим системд орлогын 48,980,464.2 мянган төгрөгийн 158 мэдээллийг байршуулахаас 42,102,891.2 мянган төгрөгийн 134 мэдээллийг хугацаанд нь байршуулж, 6,842,552.9 мянган төгрөгийн 24 мэдээллийг байршуулаагүй, зарлагын 44,053,148.2 мянган төгрөгийн 1105 мэдээлэл байршуулахаас 19,235,492.4 мянган төгрөгийн 601 мэдээллийг байршуулаагүй байна.

Дүн

1 26,078,345.2

1

26,078,345.3

-



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АКТ

0024

03

дүгээр сарын 14

№ 103/0050185

СНМ 0025/154/НА-СТА-ПчЗ

Улаанбаатар хот

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Халдварт өвчин судлалын үндэсний төвийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ.

Төлбөртэй үйлчилгээний цахим системийн кассын орлогыг Эрүүл мэндийн даатгалын сангийн И-Хелт программын орлоготой тулган шалгахад касс 3,696,300.00 /Гурван сая зургаан зуун ерэн зургаан мянга зурван зуу/ төгрөгийг дутуу тушаасан байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д "үнэн зөв байх", 13 дугаар зүйлийн 13.4-д "Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна", 20 дугаар 20.2.5-д "дансны өглөг, аалгаа ба төлбөрийн тооцоог хянах, ажил гүйлгээ гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах", Сангийн сайдын 2012 оны 276 дугаар тушаалаар баталсан "Төсвийн байгууллагын мөнгөн кассын ажиллагааны журам"-ын 2.6-д "Төсвийн байгууллага үндсэн болон туслах ажиллагаа (бусад орлого)-наас орох орлогыг мөнгөн касстаа бэлнээр хүлээн авч энэхүү орлогыг /түүнийг шууд захиран зарцуулах эрхгүй/ ажлын дараагийн өдөрт багтаан кассын нярав Төрийн сан дахь бүртгэлийн дансанд тушаана" гэсэн заалттай нийцээгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т "Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно", Монгол Улсын Ерөнхий аудиторов 2020 оны А/96 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.3.4-д "төсөвт төвлөрүүлэх ёстой татварын болон татварын бус төсвийн орлогыг төсөвт дутуу төвлөрүүлсэн эсвэл төвлөрүүлээгүй" гэж заасныг үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Төлбөртэй үйлчилгээний орлогыг төсөвт дутуу төвлөрүүлсэн 3,696,300.00 /Гурван сая зургаан зуун ерэн зургаан мянга зурван зуу/ төгрөгийг буруутай этгээдээр нөхөн төлүүлж, Үндэсний аудитын газрын Төрийн сангийн аудитын шалгалтын орлогын 100900000601 дугаар дансанд төвлөрүүлэх.
2. Төлбөрийн актын биелэлтийг 2025 оны 9 дүгээр сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Халдварт өвчин судлалын үндэсний төвийн Ерөнхий захирал /Э.Анхбаяр/, Санхүү албаны дарга, ерөнхий нягтлан бодогч /Л.Хунзаяа/ нарт даалгав.

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:

САНХҮҮ, НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
БАЯН ТАШААГИЙН ЭХ АУДИТ
ХХК-ИЙН ЗАХИРАЛ

Ц.НАРАНЧИМЭГ
В.ЭРДЭНЭЦОГТ
Т.ХОРОЛСҮРЭН



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АКТ

2025 оны 03 дугаар сарын 14 № 102/20/150/85
С.Н.П. 2025/15/1/Н.А - СТ.А-Т.М.З

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Халдварт өвчин судлалын үндэсний төвийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ.

Тус төвийн орон тоо, албан тушаалын жагсаалтын дагуу хуулийн мэргэжилтэн ажилладаг бөгөөд дахин нэг хуулийн мэргэжилтэнтэй хөлсөөр ажиллах гэрээ байгуулж ажиллуулсан. Гэрээт хуулийн мэргэжилтний ажлын гүйцэтгэлийн тайлан байхгүй мөн гэрээний хугацаа дууссанаас хойш 10 сарын ажлын хөлс 10,500,000.00 /Арван сая таван зуун мянга/ төгрөгийг олгосон байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д "үнэ зөв байх", 20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах", Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 16.5.3-т "батлагдсан цалингийн сан, орон тооны хязгаарт багтаан төсвийн байгууллагын орон тоо, ажилчдын цалин хөлсийг тогтоох" гэж тус тус заасантай нийцээгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т "шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.3.8-д "Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т заасан бусад нөхцөл, байдал үүссэн" гэж тус тус заасныг үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Батлагдсан орон тооноос илүү хуулийн мэргэжилтэн ажиллуулсан, гэрээний хугацаа дууссанаас хойш олгосон ажлын хөлс 10,500,000.00 /Арван сая таван зуун мянга/ төгрөгийг буруутай этгээдээр талүүлж, Үндэсний аудитын газрын Төрийн сангийн аудитын шалгалтын орлогын 100900000601 дугаар дансанд талвруулж.
2. Төлбөрийн актын биелэлтийг 2025 оны 9 дүгээр сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Халдварт өвчин судлалын үндэсний төвийн Ерөнхий захирал /Э.Анхбаяр/, Санхүү албаны дарга, ерөнхий нягтлан бодогч /Г.Хунзаяа/ нарт даалгав.

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:
САНХҮҮ, НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
БАЯН ТАШААГИЙН ЭХ АУДИТ
ХХК-ИЙН ЗАХИРАЛ
Ц.НАРАНЧИМЭГ
В.ЭРДЭНЭЦОГТ
Т.ХОРОЛСҮРЭН





ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

0025 03 14

Дугаар 443/005085

Үндэсний аудитын газар

СНХМ 0025/151/НА-СТ-ТЧЗ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Халдварт өвчин судлалын үндэсний төвийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тус төв нь 3 аж ахуйн нэгжтэй байгуулсан гэрээний дүнгээс 12,568,200.00 /Арван хоёр сая таван зуун жаран найман мянга хоёр зуу/ төгрөгөөр илүү эм, эмнэлгийн хэрэгсэл худалдан авсан байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.2-т "Худалдан авах гэрээний үнийг гэрээ байгуулах эрх олгосон тухай шийдвэрт заасан үнээр тогтооно", Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 41 дүгээр зүйлийн 41.2.3-т "төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнах", 41.2.6-д "төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр худалдан авах бараа ажил үйлчилгээний гүйцэтгэлийн санхүүжилтийг бараа, ажил үйлчилгээ худалдан авах ажиллагааны гэрээ, төлбөрийн хуваарийг үндэслэн санхүүжүүлэх" гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно", Монгол Улсын Ерөнхий аудиторов 2020 оны А/85 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1.8-д "байгуулсан гэрээ, хэлцэл, холбогдох дүрэм, журмыг баримтлаагүй" гэж тус тус заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Байгуулсан гэрээний үнийн дүнгээс хэтрүүлэн эм, эмнэлгийн хэрэгсэл худалдан авсан зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2025 оны 9 дүгээр сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх.
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Халдварт өвчин судлалын үндэсний төвийн Ерөнхий захирал /З.Анхбаяр/, Санхүү албаны дарга, ерөнхий нягтлан бодогч /Г.Хунзаяа/ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮ, НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
БАЯН ТАШААГИЙН ЭХ АУДИТ
ХХК-ИЙН ЗАХИРАЛ

Ц.НАРАНЧИМЭГ
В.ЭРДЭНЭЦОГТ

Т.ХОРОЛСҮРЭН





ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2025 оны 03 сарын 14 өдөр

Дугаар

444/2015085

Улаанбаатар хот

С.н.д. 2025/151/НА-СТД тус

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Халдварт өвчин судлалын үндэсний төвийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Шилэн дансны цахим системд орлогын 8,842,852,900.00 төгрөгийн 24 мэдээллийг байршуулаагүй, цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын 19,235,492,331.00 төгрөгийн 601 мэдээллийг байршуулаагүй, нийт 26,078,345,278.00 /Хорин зургаан тэрбум далан найман сая гурван зуун дөчин таван мянга хоёр зуун далан найм/ төгрөгийн мэдээллийг байршуулаагүй байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3-т "тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх", 6 дугаар зүйлийн 6.4-д "Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ", 6.4.5-д "цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр" гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1.10-т "аудитаар илэрсэн алдаа, зөрчил, түүнийг арилгахаар өгсөн зөвлөмжийг хугацаанд нь хэрэгжүүлээгүй бол" гэж тус тус заасныг үндэслэн **ШААРДАХ** нь:

1. Шилэн дансны хуулийг хэрэгжүүлээгүй, цахим системд мэдээллийг байршуулаагүй, өмнөх оны аудитаар өгсөн зөвлөмжийг биелүүлээгүй зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2025 оны 9 дүгээр сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх.
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Халдварт өвчин судлалын үндэсний төвийн Ерөнхий захирал /Э.Анхбаяр/, Санхүү албаны дарга, ерөнхий нягтлан бодогч /Г.Хунзаяа/ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮ, НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
БАЯН ТАШААГИЙН ЭХ АУДИТ
ХХК-ИЙН ЗАХИРАЛ



Ц.НАРАНЧИМЭГ
В.ЭРДЭНЭЦОГТ
Т.ХОРОГСҮРЭН

Утас: +976 51 261585

Факс: +976 11 323266, 324853

Цахим шуудан: info@audit.gov.mn

Цахим хуудас: www.audit.mn

Хаяг: Засгийн газрын IV байр

Бага тойруу-3, Чингэлтэй дүүрэг